

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	13
3.Аудитын тайлан.....	14
3.1. Ерөнхий зүйл.....	14
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	14
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	14
3.4. Материаллаг байдал	14
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	15
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	16
3.7. Шилэн дансны мэдээлэл	17
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.9. Аудитын илрүүлэлт.....	17
Залруулсан алдаа.....	17
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	17
Аудитын зөвлөмж.....	18
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	18
4. Менежментийн захидал	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	20



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

УЛСЫН ФИЛАРМОНИЙН
ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ
С.БАТТУЛГА ТАНАА

2021.02.25 № 04/553
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улсын Филарманийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн хөрөнгө өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улсын Филарманийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Улсын филарманийн 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 зорилт 4 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөн, гүйцэтгэлийг 95.7 хувьтай тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

			/төгрөгөөр/
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	127,352,658.00	166,943,864.95
33	АВЛАГА	24,874,400.00	16,700,686.95
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	00.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	24,874,400.00	1,398,200.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	00.00	14,900,000.00
335	Бусад авлага	00.00	402,486.95
3351	Байгууллагаас авах авлага	00.00	402,486.95
35	БАРАА МАТЕРИАЛ	102,478,258.00	150,243,178.00
351	Түүхий эд материал	64,036,169.00	63,336,169.00
35110	Тусгай зориулалттай материал	64,036,169.00	63,336,169.00
35130	Эм боох материал	00.00	00.00
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	00.00	00.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	1,240,000.00	33,750,000.00
354	Хангамжийн материал	37,202,089.00	53,157,009.00
35470	Бусад хангамжийн материал	37,202,089.00	53,157,009.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	446,335,338.69	761,900,988.80
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	446,335,338.69	761,900,988.80
391	Газар	00.00	00.00
392	Биет хөрөнгө	446,310,616.33	761,900,988.80
39203	Авто-тээврийн хэрэгсэл	81,800,000.00	351,800,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-73,287,999.96	-95,118,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,278,143,473.67	1,361,874,403.67
39206	Хуримтлагдсан элэгдэл	-864,005,709.19	-923,027,633.50
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	90,077,400.16	85,502,908.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-71,216,548.43	-22,330,689.49
39214	Бусад үндсэн хөрөнгө	57,832,435.72	8,000,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-53,032,435.64	-4,799,999.88
39216	Дуусаагүй барилга, байгууламж	00.00	00.00
39217	Ном	00.00	00.00
393	Биет бус хөрөнгө	24,722.36	00.00
39301	Програм хангамж	3,668,000.00	3,668,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-3,643,277.64	-3,668,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	573,687,996.69	928,844,853.75
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	15,196,293.99
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	15,196,293.99
413	Өглөг	00.00	15,196,293.99
4136	Бусад өглөг	00.00	15,195,894.00
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	14,991,320.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	00.00	204,574.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	573,687,996.69	913,648,559.76
51	Засгийн газрын хувь оролцоо	573,687,996.69	913,648,559.76
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	390,738,376.57	390,738,376.57
51101	Өмч: - төрийн	390,738,376.57	390,738,376.57
512	Хуримтлагдсан үр дүн	99,624,355.11	463,950,076.80
51210	Өмнөх үеийн үр дүн	99,624,355.11	123,989,513.73
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	339,960,563.07
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	83,325,265.01	58,960,106.39
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	573,687,996.69	928,844,853.75

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,469,904,379.00	2,871,738,530.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	282,925,580.00	397,952,930.00
120	Нийтлэг татварын бус орлого	282,925,580.00	397,952,930.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	282,925,580.00	397,952,930.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	282,925,580.00	397,952,930.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,186,978,799.00	2,473,785,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,019,132,209.00	2,410,525,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,019,132,209.00	2,410,525,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	167,846,590.00	63,260,200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,000,000.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	159,846,590.00	63,260,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,255,890,815.41	2,531,777,966.93
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,255,890,815.41	2,531,777,966.93
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,153,049,915.41	2,409,081,685.93
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,566,410,611.00	1,880,814,985.28
210101	Үндсэн цалин	1,566,410,611.00	1,350,622,689.00
210102	Нэмэгдэл	00.00	606,081.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	529,586,215.28
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	00.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	195,220,826.00	237,704,744.76
210201	Тэтгэврийн даатгал	135,307,888.00	164,866,063.71
210202	Тэтгэмжийн даатгал	15,900,987.00	19,283,902.93
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,547,988.00	15,104,124.94
210204	Ажилгүйдлийн даатгал	2,717,868.00	3,384,365.00
210205	Эрүүл мэндийн даатгал	28,746,095.00	35,066,288.18
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	00.00	00.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,260,400.00	41,260,800.00
210304	Байрны түрээс	41,260,400.00	41,260,800.00
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	00.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24,489,774.00	21,537,260.00
210401	Бичиг хэрэг	3,974,490.00	2,788,950.00
210402	Тээвэр, шатахуун	4,737,600.00	3,660,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,250,000.00	5,440,900.00
210404	Ном, хэвлэл	203,200.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,324,484.00	9,647,010.00
2105	Нормативт зардал	24,200.00	1,229,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	00.00
210502	Хоол, хүнс	00.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	24,200.00	1,229,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,446,900.00	12,805,274.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	527,400.00	00.00
210604	Урсгал засвар	16,919,500.00	12,805,274.00
2107	Томилолт, зочны зардал	4,992,000.00	00.00
210701	Гадаад албан томилолт	00.00	00.00
210702	Дотоод албан томилолт	4,992,000.00	00.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	204,944,735.00	118,133,434.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	201,371,419.00	116,605,794.00

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,500,000.00	410,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	337,716.00	343,440.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	220,900.00	262,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	352,700.00	426,200.00
210807	Газрын төлбөр	00.00	00.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	96,000.00	19,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	98,260,469.41	95,596,187.89
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	00.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	98,260,469.41	95,596,187.89
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	102,840,900.00	122,696,281.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	102,840,900.00	100,045,486.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	43,500,000.00	85,742,686.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	59,340,900.00	14,302,800.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	22,650,795.00
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	00.00
213302	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө	00.00	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	22,650,795.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	214,013,563.59	339,960,563.07
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	214,013,563.59	339,960,563.07

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>2,167,788,099.00</u>	<u>2,512,161,800.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	14,900,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	14,900,000.00
120009	Бусад орлого	00.00	14,900,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,167,788,099.00	2,497,261,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,019,132,209.00	2,410,525,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,019,132,209.00	2,410,525,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	148,655,890.00	86,736,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,000,000.00	5,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	140,655,890.00	81,736,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>2,140,348,509.00</u>	<u>2,498,952,892.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,140,348,509.00	2,498,952,892.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,038,007,609.00	2,361,356,611.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,482,262,674.00	1,786,548,589.00
210101	Үндсэн цалин	1,222,931,174.00	1,359,200,593.00
210102	Нэмэгдэл	144,939,400.00	345,251,405.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	114,392,100.00	82,096,591.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	185,293,700.00	247,934,054.00
210201	Тэтгэврийн даатгал	185,293,700.00	228,977,527.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	18,956,527.00
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	00.00	00.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,260,400.00	41,260,400.00
210304	Байрны түрээс	41,260,400.00	41,260,400.00
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	00.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,705,800.00	25,011,430.00
210401	Бичиг хэрэг	3,911,000.00	3,365,200.00
210402	Тээвэр, шатахуун	4,737,600.00	3,660,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,250,000.00	5,440,900.00
210404	Ном, хэвлэл	203,200.00	185,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,604,000.00	12,359,930.00
2105	Нормативт зардал	1,969,740.00	3,109,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	00.00
210502	Хоол, хүнс	00.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,969,740.00	3,109,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,181,550.00	14,028,474.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,530,050.00	00.00
210602	Тавилга	100,500.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	00.00

210604	Урсгал засвар	18,551,000.00	14,028,474.00
2107	Томилолт, зочны зардал	4,992,000.00	00.00
210701	Гадаад албан томилолт	00.00	00.00
210702	Дотоод албан томилолт	4,992,000.00	00.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	281,341,745.00	243,464,664.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	277,662,429.00	241,904,524.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,500,000.00	410,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	337,716.00	343,440.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	220,900.00	262,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	458,700.00	458,700.00
210807	Газрын төлбөр	00.00	00.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	96,000.00	19,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	102,340,900.00	137,596,281.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	00.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	00.00	00.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	00.00	00.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	102,340,900.00	100,045,486.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	43,500,000.00	85,742,686.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	58,840,900.00	14,302,800.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	37,550,795.00
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	00.00
213302	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө	00.00	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	37,550,795.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>27,439,590.00</u>	<u>13,208,908.00</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	27,439,590.00	13,208,908.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	27,439,590.00	13,208,908.00
2200	Дотоод эх үүсвэрээр	27,439,590.00	13,208,908.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	27,439,590.00	13,208,908.00
2260	Гадаад эх үүсвэрээр	00.00	00.00
226001	Гадаад эх үүсвэрээр	00.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-27,439,590.00</u>	<u>-13,208,908.00</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

					/төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	390,738,376.57	84,822,555.81	-115,886,499.28	359,674,433.10
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	1,497,290.80	1,497,290.80
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	390,738,376.57	84,822,555.81	-114,389,208.48	361,171,723.90
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	-1,497,290.80	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	214,013,563.59	214,013,563.59
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	390,738,376.57	83,325,265.01	99,624,355.11	573,687,996.69
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	24,365,158.62	24,365,158.62
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	390,738,376.57	83,325,265.01	123,989,513.73	598,053,155.31
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	24,365,158.62	00.00	-24,365,158.62
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	339,960,563.07	339,960,563.07
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	390,738,376.57	58,960,106.39	463,950,076.80	913,648,559.76

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,410,625,400.00	2,407,652,284.00	2,973,116.00	99.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,410,625,400.00	2,407,652,284.00	2,973,116.00	99.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,313,472,700.00	2,310,503,598.00	2,969,102.00	99.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,783,550,000.00	1,783,548,589.00	1,411.00	100.0
210101	Үндсэн цалин	1,286,344,800.00	1,356,200,593.00	-69,855,793.00	105.4
210102	Нэмэгдэл	382,813,100.00	345,251,405.00	37,561,695.00	90.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт	114,392,100.00	82,096,591.00	32,295,509.00	71.8
210104	Урамшуулал	0	0	0.00	
210105	Гэрээт ажлын хөлс	0	0	0.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	249,895,900.00	247,565,054.00	2,330,846.00	99.1
210201	Тэтгэврийн даатгал	177,037,800.00	228,608,527.00	-51,570,727.00	129.1
210202	Тэтгэмжийн даатгал	18,214,500.00	0	18,214,500.00	-
210203	ҮОМШӨ-ний даатгал	14,571,600.00	0	14,571,600.00	-
210204	Ажилгүйдлийн даатгал	3,643,000.00	0	3,643,000.00	-
210205	Эрүүл мэндийн даатгал	36,429,000.00	18,956,527.00	17,472,473.00	52.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,260,400.00	41,260,400.00	0.00	100.0
210304	Байрны түрээс	41,260,400.00	41,260,400.00	0.00	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	16,958,100.00	16,939,891.00	18,209.00	99.9
210401	Бичиг хэрэг	3,365,200.00	3,365,200.00	0.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	3,360,400.00	3,360,400.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,840,900.00	4,840,900.00	0.00	100.0
210404	Ном, хэвлэл	203,200.00	185,000.00	18,200.00	91.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0	0	0.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,188,400.00	5,188,391.00	9.00	100.0
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	0	0	0.00	
2105	Нормативт зардал	3,111,700.00	3,109,000.00	2,700.00	99.9
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0	0	0.00	
210502	Хоол, хүнс	0	0	0.00	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,111,700.00	3,109,000.00	2,700.00	99.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	218,696,600.00	218,080,664.00	615,936.00	99.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	216,784,900.00	216,520,524.00	264,376.00	99.9
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	410,000.00	410,000.00	0.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	474,000.00	343,440.00	130,560.00	72.5
210804	Тээврийн хэрэгслийн татвар	425,600.00	262,400.00	163,200.00	61.7

Улсын филарманийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	80,000.00	66,000.00	14,000.00	82.5
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	458,700.00	458,700.00	0.00	100.0
210807	Газрын төлбөр	0	0	0.00	
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	63,400.00	19,600.00	43,800.00	30.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	97,152,700.00	97,148,686.00	4,014.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	97,152,700.00	97,148,686.00	4,014.00	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	85,742,700.00	85,742,686.00	14.00	100.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0	0	0.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,410,000.00	11,406,000.00	4,000.00	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,410,625,400.00	2,407,652,284.00	2,973,116.00	99.9
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,410,625,400.00	2,407,652,284.00	2,973,116.00	99.9
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,410,625,400.00	2,407,652,284.00	2,973,116.00	99.9
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0	0.00	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	0	0.00	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	0	0	0.00	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	0	0	0.00	
610001	Төсвийн байгууллага	0	0	0.00	
610002	Төсвөөс гадуур байгууллага	0	0	0.00	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	150	150	0.00	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	130	130	0.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	19	19	0.00	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	150	150	0.00	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

			/төгрөгөөр/
Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		86,736,400.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		86,736,400.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		64,061,921.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		3,000,000.00
210101	Үндсэн цалин		3,000,000.00
210201	Тэтгэврийн даатгал		369,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал		8,071,539.00
210401	Бичиг хэрэг		00.00
210402	Тээвэр, шатахуун		300,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		600,000.00
210404	Ном, хэвлэл		-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		7,171,539.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		27,237,382.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		7,658,700.00
210602	Тавилга		4,950,208.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		-
210604	Урсгал засвар		14,628,474.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		25,384,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		25,384,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		22,674,479.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		2,896,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		2,896,800.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		00.00
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		19,777,679.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		86,736,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		86,436,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		5,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		81,736,400.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын филарманийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Улсын филарманийн захирлын үүрэг гүйцэтгэгч С.Баттулга танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах, шатахууны зарцуулалтад тооцоо бодох, и баримтаар баталгаажсан анхан шатны баримтын бүрдэл гүйцэд баримтаар гүйлгээ хийх талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 26-наас 2021 оны 02 дугаар сарын 15-ны хооронд “Гэрэлт хөхийн тэнцвэр аудит” ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Улсын филарманийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 008 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Улсын филармони үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Байгууллагын үйл ажиллагаа нь соёл урлагийн тоглолт, соёл урлагийг нийтэд таниулах түгээн дэлгэрүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Ковидтой холбоотой засгийн газрын тогтоол, шийдвэрүүд

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Улсын филарманийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,531,778.0 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 25,317.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Улсын филарманийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 355,156.8 мянган төгрөгөөр буюу 61.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, өглөг, бараа материал, үндсэн хөрөнгийн данснүүдэд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	24,874.4	16,700.7	-8,173.7
Бараа материал	102,478.3	150,243.2	47,764.9
Үндсэн хөрөнгө	446,310.6	761,900.9	315,590.4
Биет бус хөрөнгө	24.7	00.0	-24.7
Нийт хөрөнгө	573,688.0	928,844.9	355,156.9
Өр төлбөр	00.0	15,196.3	15,196.3
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	573,688.0	913,648.6	339,960.6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	573,688.0	928,844.9	355,156.9

Авлага дансны үлдэгдэл 16,700.7 мянган төгрөг болж 8,173.7 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны төлбөртэй үйлчилгээний авлагаа авсантай холбоотой. Тайлант хугацаанд буцсан гүйлгээнээс 14,900.0 мянган төгрөгийн авлага шинээр үүсч, төлбөрт үйлчилгээтэй холбоотой 1,398.2 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй байна.

Бараа материалын дансны эхний үлдэгдэл 102,478.3 мянган төгрөг ба тайлант хугацаанд улсын төсвийн хөрөнгөөр бэлэн бүтээгдэхүүнд 32,510.0 мянган төгрөг, түлш шатах тослох материалд 3,660.4 мянган төгрөг, бусад хангамжийн материалд 47,214.7 мянган төгрөг нийт 83,385.1 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор авч, 35,620.2 мянган төгрөгийн зарцуулалт хийж бараа материал дансны үлдэгдэл 150,243.2 мянган төгрөг болж өмнөх оноос 47,764.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 761,900.9 мянган төгрөг болж 315,156.9 мянган төгрөгөөр өссөн нь Соёлын яамны хөрөнгө оруулалтаар 141,161.8 мянган төгрөгийн хөгжмийн тоног төхөөрөмж, сандал, Зам тээврийн хөгжлийн яамнаас 270,000.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл тус тус шилжин ирсэн, урсгал төсвөөс 13,208.9 мянган төгрөгөөр тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авсан зэргээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгөнөөс 111,837.8 мянган төгрөгийн элэгдлээ бүрэн нөхсөн хөрөнгө Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны А-1/662 шийдвэрээр акталсан, тайлант хугацаанд 95,596.2 мянган төгрөгөөр элэгдэл байгуулсан зэргээс шалтгаалан нийт 95,596.2 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгө хасагдсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 15,196.3 мянган төгрөгөөр өссөн нь зарлагын гүйлгээ хаах өдөр хийгдсэн гүйлгээ буцаагдаж, үлдэгдлийг Сангийн яам татсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 913,648.6 мянган төгрөг болж 339,960.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд үр дүнтэй ажилласнаас шалтгаалжээ.

Улсын филарманийн 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 401,834.2 мянган төгрөгөөр буюу 16.3 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урсгал үйл ажиллагааны санхүүжилт, үнэ төлбөргүй хүлээж авсан орлого байна. Энэ нь санхүүжилт нэмэгдэж батлагдсан, үнэ төлбөргүй шилжиж ирсэн хөрөнгө өссөнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 275,887.2 мянган төгрөгөөр буюу 12.2 хувиар өссөн байна. Энэ нь ойн баярт зориулж ном хийлгэх, цахим орчинд байгууллага сурталчлах, морин хуурын клип хийлгэхтэй холбоотойгоор гэрээт ажлын зардал гарсантай холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан 24,365.2 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн залруулга нь хөрөнгө акталсантай холбоотойгоор хөрөнгийн дахин үнэлгээний зөрүүг хааснаас шалтгаалсан байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,410,625.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 2,410,525.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 2,410,525.4 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 25 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,410,625.4 мянган төгрөгийн төсөв баталснаас 2,410,625.4 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,410,525.4 мянган төгрөгийн санхүүжилт бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд цалин хөлс ба нэмэгдэл урамшуулалд 1,783,548.6 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд 247,565.1 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 41,260.4 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 16,939.9 мянган төгрөг, норматив зардалд 3,109.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжид 218,080.7 мянган төгрөг, урсгал шилжүүлэг 97,148.6 мянган төгрөг, нийт 99.9 хувийн гүйцэтгэлтэйгээр 2,407,652.3 мянган төгрөгийг зарцуулж 17,773.1 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 5,000.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 81,376.4 мянга, нийт 86,736.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бараа үйлчилгээний зардалд 64,061.9 мянга, нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 2,896.8 мянга, нийт 66,958.7 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 19,777.7 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 126 мэдээллээс хугацаандаа оруулсан 92 мэдээлэл, хугацаа хоцроосон 34 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 29,035.9 мянган төгрөгийн зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	3	29,035.9		29,035.9	-	-	-
Нийт дүн	3	29,035.9		29,035.9	-	-	-

Нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд бүлэг хооронд шилжүүлсэн 500.0 мянган төгрөг, байгууллагын үндсэн үйл ажиллагааны жил бүр давтагддаг орлогыг төлөвлөөгүй, 2019 оны 12 сарын 23-ны өдрийн Б/043, Б/064 тоот тушаалуудаар 168 хүнд олгосон 2,535.9 мянган төгрөгийн шагналын дүнг тушаалд дурдаагүй гэсэн нийт 29,035.9 мянган төгрөгийн алдаа зөрчилд зөвлөмж өгснийг биелүүлэн ажилласан байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 21,028.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, шилэн дансны хугацаа хоцроосны зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 21,028.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө

Залруулсан алдаа

Аудитаар залруулсан алдаа зөрчил байхгүй болно.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар шилэн дансны мэдээллийн хугацаа хоцроосны зөрчилд 1 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Тайлант хугацаанд байгууллагын шилэн дансны цахим хуудас байршуулах 126 мэдээллээс хугацаа хоцроосон 34 мэдээлэл байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3."тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэгт "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.5 "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Цаашид Шилэн дансны хуулийг мөрдөж алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах ажиллах талаар албан шаардлага хүргүүлэх.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 21,028.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

**3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ
ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

Цар тахалтай холбоотойгоор тухайн байгууллагад очиж хөрөнгийн хадгалалт хамгаалалт, хөрөнгийн хэсэгчилсэн тооллого хийгээгүй тул цаашид хөрөнгийн ашиглалтын хугацаа, хадгалалт, хамгаалалтын талаар дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1.Зардлын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Нийт ажил гүйлгээнээс түүвэрлэн үзэхэд цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй 17,668.0 мянган төгрөгийн худалдан авалтын гүйлгээ байгаа нь Иж бүрэн байх батламж мэдэгдлийг хэрэгжүүлээгүй, Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5-д “*Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*”, 14 дүгээр зүйлийн 14.3-д “*Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ*” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

1.2. Эрсдэл:

Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхгүй байх.

1.3. Өгсөн зөвлөмж:

Татварын ерөнхий хуулийн 28.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 14.3 дахь заалтуудыг дагаж мөрдөж ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

2.Зардлын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Түлш шатахуунд 3,360.0 мянган төгрөгийг норм нормативын дагуу зарцуулсан эсэх нь тодорхойгүй, жолоочийн тооцооны хуудсыг хянаж баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “*үнэн зөв байх*”, 13 дугаар зүйлийн 13.1-д “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*”, 14 дүгээр зүйлийн 14.3.”Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ” гэсэн заалтуудтай нийцэхгүй, Иж бүрэн байх, Үнэн зөв байх батламж мэдэгдлүүдийг мөрдөж ажиллаагүй байна.

2.2. Эрсдэл:

Төсвийн хөрөнгийг зориулалтын бус ашиглах, зарцуулах

2.3. Өгсөн зөвлөмж:

Холбогдох заавар журмын дагуу шатахууны тооцоог цаг тухай бүрд нь бодож байх

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Улсын филарманийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			САГ-2021/73/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Улсын филармони		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Шилэн дансны хуулийн дагуу 126 мэдээлэл оруулахаас 34 мэдээлэл хугацаа хоцроосон	0	Албан шаардлага өгөх	Ерөнхий нягтлан бодогч	Б.Сонинцэцэг
2	Нийт ажил гүйлгээнээс түүвэрлэн үзэхэд цахим төлбөрийн баримтаар баталгаажуагүй анхан шатны баримтаар гүйлгээ хийсэн	17,668.0	Зөвлөмж өгөх	Ерөнхий нягтлан бодогч Тооцооны нягтлан бодогч	Б.Сонинцэцэг Г.Ганжаргал
3	Түлш шатахууны тооцоо бодоогүй	3,360.0	Зөвлөмж өгөх	Ерөнхий нягтлан бодогч Тооцооны нягтлан бодогч	Б.Сонинцэцэг Г.Ганжаргал
ДҮН		21,028.0			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 158/A0160058

Улаанбаатар хот

САГ-2021/73/СТА-ТМБ
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Улсын Филармонийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд байгууллагын шилэн дансны цахим хуудас байршуулах 126 мэдээллээс хугацаа хоцроосон 34 мэдээлэл байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3."тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэгт "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.5 "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж мэдээллийг ил тод, цаг хугацаанд нь бүрэн байршуулж, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улсын Филармонийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Баттулга, нягтлан бодогч Б.Сонинцэцэг нарт даалгав

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ
ГЭРЭЛТ ХӨХИЙН ТЭНЦВЭР АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ

Д.БААТАРСАЙХАН

[illegible]

[illegible]